



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/116/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024

Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор:

Б.Азбаяр

Утас: 99061429

Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.20 № 2/18

танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯНХОНГОР СУМЫН "НОМУНДАЛАЙ"
АХЛАХ СУРГУУЛИЙН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Ц.АЛТАНГЭРЭЛ ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын Номундалай ахлах сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын Номундалай ахлах сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Номундалай ахлах сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

E:\ajil\2019 on\STA 2018\2. Nomundalai\4. Tailagnal\Аудитын гэрчилгээ.docx 2519002

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ц.Алтангэрэлд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.25-наас 2019.02.20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б. Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.15-ны өдрийн № 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Сурагч бүрийн сурлагын чанарт ахиц гарган, хүүхдийн эрхийг дээдэлж, багийн үйл ажиллагааг эрхэмлэсэн сургалт төлөвшил хөгжлийн төв бүхий сургууль байна” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Бага дунд боловсролын тухай хуулийн дагуу Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар, гадаад хэлний зохих мэдлэг эзэмшүүлэх;
- байгаль, нийгэм, хүмүүнлэг, математик, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;
- мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан амьдарч, хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэх;
- бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн "Acolous" програм хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад

дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 2 хувиар сонгов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгосон ба аккрузал сууриар бэлтгэгдсэн санхүүгийн тайлангийн хувьд дээрх үзүүлэлтийг суурь болгож авах нь зүйтэй гэж үзлээ.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2018 оны Нийт зардал 2933120,8 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 58,662.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдлийн түвшин дунд байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэв.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөг)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	15.3	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	15.3	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулав.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 2749746,1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2746678,7 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байна. Цалингийн зардал 13,8 сая төгрөгөөр хэтэрсэн байгаа нь Лабораторийн нэмэгдлийг АТГ-аас шалгалт хийж бүрэн олгож байх шаардлага өгсний дагуу цалин 13843,2 мянган төгрөгөөр дутагдаж тус зардлыг үдийн цайны зардлаас гүйлгэн зарцуулсан байна. батлагдсан өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу тогтоосон хугацаанд мэдээлбэл зохих 25 мэдээнээс 23 мэдээг хугацаандаа 2 мэдээг хугацаа хоцорч мэдээлсэн, 7 хоногийн дотор

мэдээлбэл зохих 1584,2 сая төгрөгийн 103 гүйлгээг цахим сайтад хугацаанд нь бүрэн байршуулжээ.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

3.1.1 Илрүүлэлт:

Малчны ажлын хөлсөнд 1521.0 мянган төгрөг төлсөн.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 44.3-т заасан "Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно" тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Тайлант хугацаанд бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламжийг нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлд бүрэн тусгаагүй нуун дарагдуулсан байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид малчинтай хийх гэрээнд ажлын хөлсийг туслах аж ахуйн өөрийн орлогоор санхүүжүүлэхээр зааж, малын нас дэвшилт, үр ашгийн тооцоог жил бүр хийж төсвөөс зардал гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Саналгүй

3.2 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.2.1 Илрүүлэлт:

Үдийн цайны зардлаас 13,8 сая төгрөгийг цалингийн зардалд шилжүүлэн зарцуулсан.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5-д заасан "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Төсвийн зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн зарцуулсан.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Саналгүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019.05.25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>114,892,494.73</u>	<u>160,053,438.46</u>
33	АВЛАГА	00.00	2,617,032.80
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	240,065.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	700,000.00
335	Бусад авлага	00.00	1,676,967.80
3351	Байгууллагаас авах авлага	00.00	60,200.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	1,616,767.80
35	БАРАА МАТЕРИАЛ	114,892,494.73	157,436,405.66
354	Хангамжийн материал	109,418,494.73	151,962,405.66
35410	Бичиг хэргийн материал	10,195,380.00	5,147,720.00
35420	Аж ахуйн материал	15,529,335.35	12,734,091.40
35450	Барилгын засварын материал	582,600.00	825,500.00
35460	Хүнсний материал	99,250.00	497,686.00
35470	Бусад хангамжийн материал	83,011,929.38	132,757,408.26
35600	Мал амьтад	5,474,000.00	5,474,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>903,773,521.71</u>	<u>2,457,734,124.17</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	903,773,521.71	2,457,734,124.17
392	Биет хөрөнгө	903,666,959.32	1,576,417,811.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,913,584,140.00	1,468,616,123.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,235,725,231.17	-14,250,344.98
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	582,829,616.54	608,604,462.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	-490,221,137.63	-547,140,678.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	224,502,433.16	220,888,086.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	-173,198,473.74	-179,154,545.80
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,089,927.00	00.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,273,803.72	00.00
39217	Ном	76,079,488.88	18,854,708.20
393	Биет бус хөрөнгө	106,562.39	881,316,312.35
39301	Програм хангамж	1,568,000.00	1,568,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,461,437.61	-1,546,687.65
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	881,295,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,018,666,016.44</u>	<u>2,617,787,562.63</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>1,699,260.80</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,699,260.80
413	Өглөг	00.00	1,699,260.80
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,459,195.80
4136	Бусад өглөг	00.00	240,065.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	240,065.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,018,666,016.44</u>	<u>2,616,088,301.83</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,018,666,016.44	2,616,088,301.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,602,702,027.68	2,483,997,027.68
51101	Өмч: - төрийн	1,602,702,027.68	2,483,997,027.68
512	Хуримтлагдсан үр дүн	-1,366,930,135.24	-1,487,784,164.88
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,366,930,135.24	-1,366,930,135.24
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-120,854,029.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	782,894,124.00	1,619,875,439.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,018,666,016.44</u>	<u>2,617,787,562.63</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,681,179,174.00	2,812,266,745.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,910,600.00	9,290,951.40
120	Нийтлэг татварын бус орлого	12,910,600.00	9,290,951.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,910,600.00	9,290,951.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,411,000.00	3,900,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,499,600.00	5,390,951.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	57,870,274.00	79,946,693.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	9,628,266.00	00.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	9,628,266.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,610,398,300.00	2,723,029,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,721,340.00	54,863,208.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,721,340.00	29,826,208.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	25,037,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	41,520,668.00	25,083,485.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	41,520,668.00	25,083,485.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,784,054,513.46	2,932,562,228.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,784,054,513.46	2,932,562,228.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,357,427,056.46	2,717,770,008.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,495,736,945.00	1,702,086,013.00
210101	Үндсэн цалин	1,414,021,226.00	1,599,469,995.00
210104	Урамшуулал	81,715,719.00	102,616,018.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,975,754.00	204,575,753.90
210201	Тэтгэврийн даатгал	111,200,111.00	136,989,527.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,861,790.00	17,066,062.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,021,500.00	13,708,581.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,717,486.00	3,304,329.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,174,867.00	33,507,254.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	385,992,182.00	458,411,138.32
210301	Гэрэл, цахилгаан	19,432,760.00	20,104,220.72
210302	Түлш, халаалт	320,237,172.00	363,570,544.00
210303	Цэвэр, бохир ус	46,322,250.00	74,736,373.60
2104	Хангамж, бараа материалын зардал	23,093,064.00	104,523,633.56
210401	Бичиг хэрэг	4,246,650.00	8,596,375.00
210402	Тээвэр, шатахуун	1,857,644.00	1,393,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,932,838.00	6,339,681.41
210404	Ном, хэвлэл	00.00	60,885,080.68
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,803,932.00	27,309,096.47
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	252,000.00	00.00
2105	Нормативт зардал	100,302,558.00	84,534,494.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,262,600.00	749,500.00
210502	Хоол, хүнс	96,423,518.00	82,331,464.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,616,440.00	1,453,530.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,561,500.00	10,071,050.00
210604	Урсгал засвар	14,561,500.00	10,071,050.00
2107	Томилолт, зочны зардал	3,277,400.00	1,629,900.00

Баянхонгор сумын Номундалай ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	3,277,400.00	1,629,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,957,000.00	5,164,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,957,000.00	5,164,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161,530,653.46	146,773,625.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,664,970.00	17,835,740.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	245,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	150,465,683.46	128,692,885.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	426,627,457.00	214,792,220.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	426,002,657.00	211,724,847.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	41,520,668.00	25,083,485.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	81,401,420.00	84,835,412.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	66,778,169.00	76,856,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	179,549,400.00	23,995,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	56,753,000.00	953,550.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	624,800.00	3,067,373.07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	624,800.00	3,067,373.07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-102,875,339.46	-120,295,483.68
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	558,545.96
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	558,545.96
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-558,545.96
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-102,875,339.46	-120,854,029.64

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,662,051,308.00	2,805,355,793.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,411,000.00	3,900,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,411,000.00	3,900,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,411,000.00	3,900,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,411,000.00	3,900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,658,640,308.00	2,801,455,793.70
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,610,398,300.00	2,723,029,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,721,340.00	53,343,208.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,721,340.00	29,826,208.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	23,517,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	41,520,668.00	25,083,485.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	41,520,668.00	25,083,485.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,662,051,308.00	2,784,388,793.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,662,051,308.00	2,784,388,793.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,235,497,851.00	2,568,759,223.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,502,772,799.00	1,693,542,688.00
210101	Үндсэн цалин	1,136,651,299.00	1,245,330,188.00
210102	Нэмэгдэл	290,670,300.00	364,558,700.00
210104	Урамшуулал	75,451,200.00	83,653,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	159,190,600.00	213,254,000.90

Баянхонгор сумын Номундалай ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210201	Тэтгэврийн даатгал	101,877,700.00	156,752,400.90
210202	Тэтгэмжийн даатгал	11,462,500.00	8,884,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,328,200.00	12,698,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,865,700.00	3,174,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,656,500.00	31,745,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	385,992,182.00	458,411,138.32
210301	Гэрэл, цахилгаан	19,432,760.00	20,104,220.72
210302	Түлш, халаалт	320,237,172.00	363,570,544.00
210303	Цэвэр, бохир ус	46,322,250.00	74,736,373.60
2104	Хангамж, бараа материалын зардал	24,905,602.00	16,257,162.39
210401	Бичиг хэрэг	4,094,900.00	3,407,635.00
210402	Тээвэр, шатахуун	1,857,644.00	1,393,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,932,838.00	3,446,847.39
210404	Ном, хэвлэл	4,038,600.00	89,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,981,620.00	7,920,280.00
2105	Нормативт зардал	107,255,318.00	85,324,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,262,600.00	749,500.00
210502	Хоол, хүнс	95,108,318.00	82,729,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,884,400.00	1,844,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,659,400.00	6,594,000.00
210604	Урсгал засвар	14,659,400.00	6,594,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,277,400.00	1,629,900.00
210702	Дотоод албан томилолт	3,277,400.00	1,629,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,479,240.00	11,137,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,479,240.00	11,137,850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,965,310.00	82,608,484.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,565,310.00	32,142,134.02
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	50,466,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	426,553,457.00	215,629,570.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	425,928,657.00	211,862,197.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	41,520,668.00	25,083,485.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	81,401,420.00	84,866,812.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	66,778,169.00	76,856,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	179,549,400.00	23,995,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	56,679,000.00	1,059,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	624,800.00	3,067,373.07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	624,800.00	3,067,373.07
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	700,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	700,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	20,967,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	20,967,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	20,967,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	20,967,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	20,967,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-20,967,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.01	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.01	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,602,702,027.68	782,894,124.00	-1,264,054,795.77	00.00	1,121,541,355.91
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,602,702,027.68	782,894,124.00	-1,264,054,795.77	00.00	1,121,541,355.91
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-143,044,864.93	00.00	-143,044,864.93
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,602,702,027.68	782,894,124.00	-1,366,930,135.24	00.00	1,018,666,016.44
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,602,702,027.68	782,894,124.00	-1,366,930,135.24	00.00	1,018,666,016.44
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,602,702,027.68	782,894,124.00	-1,366,930,135.24	00.00	1,018,666,016.44
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	836,981,315.03	00.00	00.00	836,981,315.03
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	881,295,000.00	00.00	-120,854,029.64	00.00	760,440,970.36
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,483,997,027.68	1,619,875,439.03	-1,487,784,164.88	00.00	2,616,088,301.83

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,121,445,700.00	2,077,177,759.00	2,726,229,100.00	2,722,461,726.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,121,445,700.00	2,077,177,759.00	2,726,229,100.00	2,722,461,726.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,027,376,600.00	1,983,174,659.19	2,526,218,800.00	2,535,683,014.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,382,395,600.00	1,373,567,083.19	1,643,281,600.00	1,656,944,829.30
210101	Үндсэн цалин	949,164,400.00	899,389,431.00	1,194,889,100.00	1,208,732,329.30
210102	Нэмэгдэл	365,935,200.00	347,465,283.84	364,558,700.00	364,558,700.00
210104	Урамшуулал	67,296,000.00	126,712,368.35	83,833,800.00	83,653,800.00

Баянхонгор сумын Номундалай ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,063,500.00	152,063,500.00	213,254,000.00	213,254,000.90
210201	Тэтгэврийн даатгал	96,767,700.00	96,767,700.00	156,752,400.00	156,752,400.90
210202	Тэтгэмжийн даатгал	11,059,200.00	11,059,200.00	8,884,100.00	8,884,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,823,900.00	13,823,900.00	12,698,000.00	12,698,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,764,800.00	2,764,800.00	3,174,500.00	3,174,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,647,900.00	27,647,900.00	31,745,000.00	31,745,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	327,336,200.00	293,204,339.00	461,082,000.00	458,411,138.32
210301	Гэрэл, цахилгаан	18,216,100.00	18,842,743.00	20,766,200.00	20,104,220.72
210302	Түлш, халаалт	265,255,600.00	229,838,931.00	365,579,400.00	363,570,544.00
210303	Цэвэр, бохир ус	43,864,500.00	44,522,665.00	74,736,400.00	74,736,373.60
2104	Хангамж, бараа материалын зардал	15,814,300.00	15,453,627.00	17,684,300.00	16,861,662.39
210401	Бичиг хэрэг	2,389,800.00	2,234,490.00	3,407,600.00	3,407,635.00
210402	Тээвэр, шатахуун	1,257,300.00	1,260,900.00	1,393,400.00	1,393,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,006,600.00	4,515,227.00	4,893,500.00	3,790,847.39
210404	Ном, хэвлэл	3,153,800.00	1,766,910.00	69,500.00	349,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,006,800.00	5,676,100.00	7,920,300.00	7,920,280.00
2105	Нормативт зардал	122,714,800.00	122,581,260.00	85,324,000.00	85,324,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	651,100.00	691,520.00	749,500.00	749,500.00
210502	Хоол, хүнс	118,359,200.00	118,754,940.00	82,729,900.00	82,729,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,704,500.00	3,134,800.00	1,844,600.00	1,844,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,330,800.00	4,330,800.00	6,594,000.00	6,594,000.00
210604	Урсгал засвар	4,330,800.00	4,330,800.00	6,594,000.00	6,594,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,411,500.00	2,412,000.00	1,629,900.00	1,629,900.00
210702	Дотоод албан томилолт	2,411,500.00	2,412,000.00	1,629,900.00	1,629,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,259,400.00	1,682,780.00	2,945,300.00	2,240,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,259,400.00	1,682,780.00	2,945,300.00	2,240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	180,505,000.00	178,792,700.00	944,237,000.00	944,234,840.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,050,500.00	17,879,270.00	43,957,200.00	43,957,134.02
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	50,466,500.00	50,466,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	940,691,000.00	940,030,999.81	2,000,103,000.00	1,867,787,120.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,069,100.00	94,003,099.81	200,010,300.00	186,778,712.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66,657,100.00	66,657,099.81	98,098,400.00	84,866,812.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	00.00	76,856,800.00	76,856,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,796,000.00	25,796,000.00	23,995,600.00	23,995,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,616,000.00	1,550,000.00	1,059,500.00	1,059,500.00

Баянхонгор сумын Номундалай ахлах сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,121,445,700.00	2,076,877,759.00	2,726,229,100.00	2,722,461,726.93
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,119,945,700.00	2,075,867,862.00	2,723,029,100.00	2,719,261,726.93
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,119,945,700.00	2,075,867,862.00	2,723,029,100.00	2,719,261,726.93
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,500,000.00	1,009,897.00	3,200,000.00	3,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	1,009,897.00	3,200,000.00	3,200,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	164.00	154.00	158.00	158.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	108.00	108.00	111.00	111.00
620003	Үйлчлэх ажилтан	55.00	45.00	46.00	46.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	2,378.00	2,378.00	2,378.00	2,378.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	2,378.00	2,378.00	2,378.00	2,378.00
630001	Төрийн өмчит ЕБС	2,378.00	2,378.00	2,378.00	2,378.00